



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 09 өдөр

Дугаар A/38

Улаанбаатар хот


### Улаанбаатар олон улсын хоолны фестиваль зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Арга хэмжээ зохион байгуулах тухай" А/890 дугаар захирамж, "Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан Газрын дүрмийн 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, Монгол хоолны соёлыг гадаад, дотоодод таниулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Улаанбаатар олон улсын хоолны фестиваль"-ыг 2023 оны 08 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсугай.

2. Энэ тушаалын хавсралтад заасан арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 81.650.000 (наян нэгэн сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Уянга/-д зөвшөөрсүгэй.

3. Арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2023 оны 08 сарын 09 өдрийн  
А/39 дугаар тушаалын хавсралт



“УЛААНБААТАР ОЛОН УЛСЫН ХООЛНЫ ФЕСТИВАЛЬ”  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Шторк хийх	Багц	1	9.000.000	9.000.000
2	Арга хэмжээний контент бэлтгэж гаргах				
3	Телевизүүдээр шторк цацах	Тоо	3	1.000.000	3.000.000
4	Facebook бүүст	Тоо	1	500 000	500 000
5	Тайз, дэлгэц, хөгжим, карказ, гэрлийн түрээс	3 өдөр	1	23.550.000	23.550.000
6	Асар түрээс 5x5 /зөөвөрлөх, байршуулах/	ш	6x3 өдөр	150.000	900.000
7	Хөтлөгчийн зардал	Тоо	3 өдөр 2 хүн	1.000.000	6.000.000
8	Үйлчилгээний ажилтны хөлс	Тоо	3 өдөр 10 хүн	60.000	1.800.000
9	Харуул, хамгаалалтын зардал	Тоо	4 хүн 2 өдөр	200.000	1.600.000
10	Урлагийн тоглолтын зардал	Тоо	3 өдөр	3.500.000	10.500.000
11	Ширээ 20ш, сандал 40ш түрээслэх /зөөвөрлөх, байршуулах/	Тоо	3 өдөр	10.000	600.000
12	08 дугаар сарын 18,19,20-ны өдрийн үндсэн хоолны үзүүлбэрийн материал /Шарсан хонь, олон хүний плов, халуун ажиллагааны үзүүлбэр гэх мэт/	Багц	3	1.000.000	3.000.000
13	Хоолны үзүүлбэрийн тогоочийн ажлын хөлс	Хүн	4*3=12	700.000	8.400.000
14	Арга хэмжээний хөтөч тогоочийн ажлын хөлс	Багц	2*3=6	300.000	1.800.000
15	Ерөнхий тогоочийн багийн ажлын хөлс /арга хэмжээнд оролцож байгаа хоол үйлдвэрлэгч нарт техникийн зөвлөгөө өгөх, меню, порц, халуун ажиллагаанд хяналт тавих, оролцогчдын хоолны үзүүлбэрүүдийг зохион байгуулах зэрэг/	Баг	1	5.000.000	5.000.000
16	Талбайн тохижилтын зардал	Баг	1	5.000.000	5.000.000
НИЙТ ДҮН:					81.650.000

--- оОо ---